



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/57

Булган сум

Газрын хэмжээ өөрчлөх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Г.Эрдэнэбаяр (ГМ90033015)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 15 дугаар гудамж 1528 тоотод байршилтай 6308004564 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 700 м<sup>2</sup> газрыг 772 м<sup>2</sup>, Т.Одгэрэл (ГЭ77071102)-ийн эзэмшиж буй Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 4 дүгээр гудамж 403 тоотод байршилтай үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 1407 м<sup>2</sup> газрыг 1420 м<sup>2</sup> болгон илүү талбайн дуудлага худалдааны анхны үнийг тус тус төлүүлэн кадастрын зураглалын дагуу газрын хэмжээг өөрчилсүгэй.

2. Г.Эрдэнэбаяр, Т.Одгэрэл нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/287 дугаар захирамжийн Г.Эрдэнэбаяр, 2020 оны А/149 дүгээр захирамжийн Т.Одгэрэл нартай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ